



ЭРДЭНЭСАНТ СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

ҮАГ-ын Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?
Л.Жаргалсайхан
Аймгийн Тэргүүлэх аудитор
өрөөний утас 70272582

Ц.Саранчимэг - Аудитор
өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Эрдэнэсант сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Эрдэнэсант сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Эрдэнэсант сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- Орон нутгийн төсвийн татварын орлогыг тодотгож 40779,4 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 34069,1 мянган төгрөг төвлөрүүлж 6710,3 мянган төгрөгөөр буюу 83,5 хувиар татварын орлогын төлөвлөгөө тасарсан байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудын дутуу хийгдсэн ажлыг авлагаар бүртгээгүй байна.

*ЕМ, Санхүүгийн албанаас
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудитор т санал оруулсан байгаа

- ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.25-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Танилцуулга

Эрдэнэсант сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Эрдэнэсант сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Эрдэнэсант сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Эрдэнэсант сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Эрдэнэсант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12-р сарын 19-ний өдрийн 02-р хуралдааны 01-р тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 38779,4 мянган төгрөгөөр баталсан ба тайлант онд орлогыг тодотгож 40779,4 мянган төгрөг ба гүйцэтгэлээр 34069,1 мянган төгрөг төвлөрч батлагдсан 6710,3 мянган төгрөгөөр буюу 83,5 хувиар тасарсан байна. Энэ нь ноосны урамшуулалаас авах татвар буюу үйл ажиллагааны орлого 32546,6 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 16463,2 мянган төгрөг орж 16083,4 мянган төгрөгөөр буюу 49,4 хувиар тасарсантай холбоотой байна.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 121908,8 мянган төгрөг, гүйцэтгэлээр 133403,6 мянган төгрөг буюу биелэлт 109,4 хувьтай, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 17100,0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 79857,6 мянган төгрөг биелэлт 467,0 хувиар тус тус биелэсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 1089,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 34069,1 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 306377,4 мянган төгрөг, нийт 340446,4 мянган төгрөг төвлөрч, санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 202170,7 мянган төгрөг, ИТХуралд 38965,0 мянган төгрөг, Багт 65241,6 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс

ЗДТГазарт 20235,6 мянган төгрөг буюу нийт 326613,0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 828627,0 мянган төгрөг, Цэцэрлэгт 238253,0 мянган төгрөг, Эмнэлэгт 267562,1 мянган төгрөг, Соёлын төвд 60548,7 мянган төгрөг нийт 1394990,8 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна. Дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 8181,3 мянган төгрөгийг, НЕҮйлчилгээний байгууллагуудын оны эхний харилцах дансны үлдэгдэл 9724,3 мянган төгрөгийг болон оны эцсийн зарцуулаагүй үлдэгдэл 5638,8 мянган төгрөгийг тус тус татан төвлөрүүлсэн байна

Халамжийн сангийн санхүүжилт 296825,5 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 216600,5 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 67020,0 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 12520,0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 685,0 мянган төгрөг зарцуулсан байна. 2011,0 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 39706,1 мянган төгрөг, Сургууль 3453,8 мянган төгрөг, Цэцэрлэг 2000,0 мянган төгрөг, Соёлын төв 1695,7 мянган төгрөг нийт 46855,6 мянган төгрөгийн орлого, 37879,6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 5522,2 мянган төгрөгийн үлдэгдэлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэгтгэсэн. Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 539,5 мянган төгрөг, Соёлын төв 1090,4 мянган төгрөг, ЭМТөв 585,3 мянган төгрөг, Сургууль 521,2 мянган төгрөг, нийт 2736,4 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 2618,9 мянган төгрөг, ИТХурал 1435,3 мянган төгрөг, Баг 5670,0 мянган төгрөг нийт 9724,3 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 27867,4 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 1089,9 мянган төгрөг, эм эргэлтийн сан 21715,0 мянган төгрөг, нийт 60396,6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 18722,9 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 14919,5 мянган төгрөг, эм эргэлтийн сан 29003,4 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 5522,2 нийт 68168,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 55109,4 мянган төгрөгийн авлага, оны эцэст 218953,4 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 163844,0 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 218925,7 мянган төгрөгийн буюу 99,9 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Өглөг оны эхэнд үлдэгдэлгүй, оны эцэст 3283,0 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эцэст НЕҮ-ний шатахуун, томилолт, урсгал зардал, бусад зардал 3283,0 мянган төгрөг байна

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 110790,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 321745,7 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 319178,8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 113356,9 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 3610866,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 190346,4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 25862,9 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 3775349,7 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 158649,6 мянган төгрөг үлдэх өртөг 2515427,9 мянган төгрөг байна

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Байгаль хамгаалах сангийн талаар:

Байгаль хамгаалах сан оны эхний үлдэгдэл 2143,0 мянган төгрөг, байгаль хамгаалах сангийн санхүүжилт 5430,0 мянган төгрөг, хогны хаягдлын төлбөрөөс 272,0 мянган төгрөг, аймгаас биотехникын арга хэмжээний зардалд 250,0 мянган төгрөг нийт 5952,0 мянган төгрөгийн орлого бүрдэж хог тээврийн шатахуунд 421,2 мянган төгрөг, байгаль хамгаалагчийн эргүүлийн шатахуун 147,2 мянган төгрөг, нийтийн цэвэрлэгээний зардалд 600,0 мянган төгрөг, сургуульд эко танхим байгуулах зардалд 1600,0 мянган төгрөг нийт 5768,4 мянган төгрөг зарцуулж 5326,6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Сургуульд эко танхим байгуулахаар бэлнээр гарсан 1600,0 мянган төгрөгийн баримтын бүрдэл хангалтгүй дутуу байна. Эко танхимыг 1000,0 мянган төгрөгөөр тохижуулахад захилгаа өгсөн үлдэгдэл 600,0 мянган төгрөгөөр байгаль хамгаалагчийн эргүүл хийсэн шатахуун болон бусад зардалд зарцуулсан гэж тайлагнасан боловч баримтын бүрдэлгүй байна. Бусад зардлын хувьд анхан шатны баримтын бүрдэл сайн, ажил гүйлгээг үндсэн баримтанд үндэслэж хийгдсэн байна.

Тайлант онд сургуульд эко танхим байгуулахаар 1600,0 мянган төгрөг бэлнээр гарсан зардлаас хогийн цэгийн засвар өргөстэй тор, шонгийн мод худалдан авахад 300,0 мянган төгрөг, хогийн цэгийн доторх зам гаргах, овооны хог хаягдал цэвэрлэх шатахуунд 80,3 мянган төгрөг, ан амьтдын тооллого хяналт шалгалт хийх, хууль бусаар мод түлээ бэлтгэх, хог хаягдал цэвэрлэх, хужир шүү бэлтгэх явцад хяналт тавих ажлын шатахууны зардалд 220,0 мянган төгрөг зарцуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн хөгжлийн санд тайлант онд 168646,4 мянган төгрөгийн орлого, 90 ойн хандив 127705,4 мянган төгрөг нийт 296351,8 мянган төгрөг төвлөрч 170598,3 мянган төгрөгийн зарлага, 90 ойн арга хэмжээний зарлага 124464,4 мянган төгрөг гарч үлдэгдэл 1289,1 мянган төгрөг байна. Хандивын орлогоос 5000,0 мянган төгрөгийг хандив өргөсөн иргэн буцааж авах хүсэлт тавьсан тул буцааж олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг эрэмбэлэгдсэн жагсаалтын дагуу бараа ажил үйлчилгээнд Монгол улсын ЗНТУТХуулийн 29,2, төсвийн тухай хуулийн 16,5,5, 58,4,8 зүйл заалт ТБОНӨХБАҮХАТХуулийн 7-р зүйл 29.2 сангийн сайдын 2013,02,21-ны өдрийн 39 тушаалын 1-р хавсралтаар батлагдсан Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам, ЗГ-ын 2013.03.02-ны өдрийн босго үнэ шинэчлэн батлах тухай 68-р тогтоол, сумын ИТХ-ын 2013,01,28-ны өдрийн хуралдааны Орон нутгийн хөгжлийн сангийн эрэмбэлсэн жагсаалт батлах тухай 04 тоот тогтоолыг үндэслэн худалдан ажиллагаатай холбоотой ажил үйлчилгээг явуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас Ахуй үйлчилгээний төв байгуулах ажлын гэрээгээр Мөнгөнбулаг ХХК-д /гэрээний №13/07/ 60,0 сая төгрөгөөр ахуй үйлчилгээний төв бариулахаар 1 жилийн хугацаатай гэрээлж гэрээний нөхцлийн дагуу 53598,3 мянган төгрөгийг шилжүүлсэн. Үлдэгдэл 6401,7 мянган төгрөгийн санхүүжилт дутуу өгсөн. Үерийн усны гуу жалга тэгшлэх бетондох ажлын гэрээ №13/29 Чинжаргал ХХК-тай 40.0 сая төгрөгийн гэрээ байгуулж гэрээний нөхцлийн дагуу 32.0 сая төгрөгийг тайлант онд санхүүжүүлсэн байна. Үлдэгдэл төлбөр болох 8.0 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлийг дууссаны дараа санхүүжүүлэхээр гэрээ хийгдсэн ажил дуусаагүй байна.

Наадмын талбай бариулах ажлыг Баян-уул нөхөрлөлтэй 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулж ажлыг хүлээн авч төлбөрийг шилжүүлсэн байна.

Сумын төвийн “Зам гудамж хорооллын гэрэлтүүлэгийг нэмэгдүүлэх” ажлын гүйцэтгэгч иргэн Б.Буянхишигтэй гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлийг хүлээн авч төлбөр 10.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Гэрэлтүүлэгийг ЗДТГазрын балансад бүртгэж авч тусгасан байна.

Малжуулах төсөлд 5 багийн 10 иргэнийг хамруулж гэрээг малжуулах айл, төсөлд хамрагдсан иргэн, сумын ЗДТГазартай гурвалсан гэрээ байгуулан нийт 20.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Малжуулах төсөлд хамрагдах малчдыг багийн иргэдийн нийтийн хурлаар баг тус бүрээс төсөлд хамрагдах иргэдийг хэлэлцэж 2 иргэнийг сонгон шалгаруулж нэг өрхөд тус бүр 20 эм хонь нэг бүрийг 100.0 мянган төгрөгөөр худалдан авч өгсөн байна.

Сумын баяр наадмын үйл ажиллагааны зардалд 5.0 сая төгрөг зарцуулсан байна.

Усны машин Евротрак ХХК-аас 30.0 сая төгрөгөөр худалдан авч ЗДТГазрын баланс тусгасан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудын дутуу хийгдсэн ажлыг авлагаар бүртгээгүй байна.

Сумын 90 жилээр хандив 127705.4 төгрөг төвлөрч үүнээс 90 жилийн ойн хандив цуглуулах үйл ажиллагааны зардалд 3358.0 мянган төгрөг, бэлэг дурсгалын зүйлсийг МОТТОО ХХК-тай гэрээ байгуулан зардалд /аяга медаль, тэмдэг, уут/ 36863.5 мянган төгрөг, 90 жилийн ой угтаж зохион байгуулсан бадан бөөрийн шагайн харвааны зардалд 2441.0 мянган төгрөг, урлаг уран сайхны үйл ажиллагаанд урлагийн тоглолт, нээлтийн үйл ажиллагааны морин үзүүлбэр зэрэгт 18302.9 мянган төгрөг, наадмын талбайн тохижилтонд 22398.9 мянган төгрөг, баяр наадмын ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд 3041.0 мянган төгрөг, цагдаагийн кубоны тохижилтонд 1000.0 мянган төгрөг, худгийн засварт 2000.0 мянган төгрөг, хандиваа буцаасан 5000.0 мянган төгрөг, аймгийн 90 жилийн ойн баяр наадамд оролцох зардалд 1500.0 мянган төгрөг, морь бөхийн бай шагналд 25313.5 мянган төгрөг, шатахууны зардалд 3245.6 мянган төгрөг зарцуулж 3241.0 мянган төгрөгийн хандивын үлдэгдэл үлдсэн байна. 90 жилийн ойн арга

хэмжээний зардлын баримтын бүрдэл сайн гэрээ байгуулан олгосон байна. Үүний дотор бадын бөөрийн шагайн харвааны зардлаас урлагийн тоглолтын хөлс иргэн Д.Баасанжаргалд 300.0 мянган төгрөг, сумын наадмын оройн хүндэтгэлийн хүлээн авалтанд урлагийн тоглолтын ажлын хөлс 500.0 мянган төгрөгийг бэлэн мөнгө олгох жагсаалтаар гарын үсэг зуруулж олгосон байна. Гэрээ байгуулсан болон анхан шатны баримтын бүрдэл бүрэн бус байна.

Мал хамгаалах сангийн талаар:

Мал хамгаалах сангийн эхний үлдэгдэл 14103.6 мянган төгрөг өвс тэжээл борлуулсны орлого 9950.4 мянган төгрөг өвс худалдан авахад 10162.0 мянган төгрөг, өвс тээвэрлэх шатахууны зардалд 2460.0 мянган төгрөг, хөдөөгийн багуудаар өвөлжилт, хаваржилт, төл бойжилтын явцтай танилцах шатахуунд 998.4 мянган төгрөг, өвс хураасан иргэдэд олгосон урамшуулал 220.0 мянган төгрөг нийт 13840.4 мянган төгрөг зарцуулж үлдэгдэл 10213.6 мянган төгрөг байна.

Өвс худалдан авахад аймгийн засаг даргын 2012.12.18-ны А/638 тоот захирамжийн дагуу сумын нөөцөд өвс нөөцлөхөд Тосон овоот хайрхан ХХК-тай гэрээ байгуулан 1230 боодол өвсийг нэг бүрийн үнэ 5000 төгрөгөөр тооцож 6150.0 мянган төгрөг, шатахууны зардлыг нэг боодол өвсөнд 2000 төгрөгөөр тооцож 2460.0 мянган төгрөгийг гэрээ нэхэмжлэлийг үндэслэн шилжүүлсэн байна. Аймгийн засаг даргын 2013 оны А/336 тоот захирамжийн дагуу сумын нөөцөд өвс нөөцлөхөд Иргэн Д.Болдбаатартай гэрээ байгуулан 1003 боодол өвсийг нэг бүрийн үнэ 4000 төгрөгөөр тооцож 4012.0 мянган төгрөгийг гэрээ нэхэмжлэл татвар төлөгчийн цэнхэр дэвтэрийг үндэслэн шилжүүлсэн байна. Гэрээгээр ирсэн өвсийг буулгаж хураахад 8 иргэн ажиллуулж 220.0 мянган төгрөгийн урамшуулал олгож ХАОАТ-ын тооцон шилжүүлсэн баримтын бүрдэл бүрэн байна. Сумын засаг даргын захирамжаар цас зайлуулах, цасанд боогдсон айлуудын хооронд зам гаргах ажилд Эрдэнэсант АЗЗА-ТӨХК-д 600.0 мянган төгрөгийг шатахууны зардал олгох, ОБГазраас ирүүлсэн зам гаргах автомашины шатахууны зардалд 160.0 мянган төгрөг, мал хаваржилтын байдалтай танилцах ажлын хэсгийн шатахууны зардалд 238.4 мянган төгрөгийг ШТГазарт шилжүүлэн зарцуулсан байна. Энэ хугацаанд сар бүрийн кассын орлого зарлагын тайланг гаргадаггүй зөрчил байна. Оны эхэнд 18414.0 мянган төгрөгийн 4425 ш өвс ногоон тэжээл байсан. Тайлант онд нийт 2808 ш ногоон тэжээл өвс зарж 9950.0 мянган төгрөгийн орлого оруулсан. Үлдэгдэл 1617 боодол өвс буюу 6966.0 мянган төгрөгийн үлдэгдэл байна. Энэ нь материалын тайлангийн дүнтэй тохирч нотлогдож байна. Өвс борлуулсан орлогыг хувь хүнээр нь төрийн сангийн дансанд тушаалгаж тушаасан баримтыг үндэслэн өвсийг олгосон байна.

Сүм хөгжүүлэх сангийн талаар:

Тайлант оны эхний үлдэгдэл 10563.9 мянган төгрөг тайлант оны санхүүжилт 120000.0 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлт 25887.4 мянган төгрөг, зээлийн хүү 8695.5 мянган төгрөг нийт орлого 156582.9 мянган төгрөг байна. Тайлант онд 165490.0 мянган төгрөгийн зээл олгосон. Жилийн эцэст 1656.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Засаг даргын 2013 оны тоот захирамжаар зээл олгох үнэлгээний комиссыг 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Үүнд иргэний төлөөлөл 5, ИТХурлын төлөөлөгч 6, төрийн албан хаагчаас 6 хүн орсон байна. 3 удаагийн хурлаар 64 төсөл 237500.0 мянган төгрөгийн төсөл ирснээс 19 иргэнд 165490.0 мянган төгрөгийн зээлийг гэрээ байгуулан олгосон байна. Зээлийг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилж үзвэл фермерийн

чиглэлээр 2 иргэнд 7990.0 мянган төгрөг, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд 1 иргэнд 20000,0 мянган төгрөг, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж бэлтгэхэд 1 ААН-д 10000,0 мянган төгрөг, засвар үйлчилгээний чиглэлээр 4 иргэнд 44000,0 мянган төгрөг, гахайн аж ахуй 1 ААН-д 9000.0 мянган төгрөг, блок үйлдвэрлэлд 2 иргэнд 7000.0 мянган төгрөг, хүнсний дэлгүүр, цайны газарт 2 иргэнд 9000.0 мянган төгрөг, оёдол ахуй үйлчилгээний чиглэлээр 5 иргэнд 26500,0 мянган төгрөг, арьс шир түүхий эд боловсруулах чиглэлээр 1 иргэнд 30000.0 мянган төгрөгийн зээл олгож шинээр 70 ажлын байр бий болсон байна. Шинээр бий болсон ажлын байрыг сайн дурын даатгалд хамруулан баталгаажуулсан байна.

Тайлант оны эхний үлдэгдэл 53835.6 мянган төгрөгийн зээлийн авлагатай байсан. Тайлант онд 19 иргэнд 165490.0 мянган төгрөгийн авлага нэмэгдэж тайлант оны эцсээр 32 хүний 218925.7 мянган төгрөгийн авлагатай гарсан байна

Хяналт шалгалтыг сумын ИТХурлын тогтоолоор байгуулагдсан 5 төлөөлөгч төрийн албан хаагч 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон сар бүр зээлийн зориулалт үйл ажиллагаа ажлын байрыг тогтмол шалгадаг. Тайлант онд сумын ажлын хэсгийн 7 удаагийн хяналт шалгалт, Хөдөлмөрийн хэлтсээс 2 удаагийн хяналт шалгалт хийгдсэн байна. Хяналт шалгалтаар хугацаа хэтэрсэн 3 иргэний 6915.0 мянган төгрөгийн зээл төлүүлэх мэдэгдэлийг хүргүүлж хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Байгаль орчин нөхөн сэргээлтийн сангийн талаар:

Цэвэр усан сангийн эхний үлдэгдэл 443.3 мянган төгрөг усны төлбөрөөс 1020.2 мянган төгрөгийн орлого орж 1178.5 мянган төгрөгийг цахилгааны зардал, худгийн сэлбэг 285.0 мянган төгрөгийн зардалд гарч жилийн эцсээр үлдэгдэлгүй байна. 285.0 мянган төгрөгөөс усны машины аккумулятор авсан зардалд 170.0 мянган төгрөг, худгийн сэлбэгт 115.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Баримтын бүрдэл сайн албажсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн талаар:

Тайлант оны эхний үлдэгдэл 613.6 мянган төгрөг ИТХурлаас 2862.3 мянган төгрөгийн орлого орж драйгер төхөөрөмж 450.0 мянган төгрөг, шатахууны зардалд 1385.2 мянган төгрөг, сургалт сурталчилгааны зардалд 979.7 мянган төгрөг, тэмцээний зардалд 292.5 мянган төгрөг, хуулиа дээдлэе тэмцээнд оролцох хүүхдийн хувцасны үнэ 111.5 мянган төгрөг, малчдын бүлгийн холбооны зардалд 20.0 мянган төгрөг нийт 3238.9 мянган төгрөг зарцуулж 236.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна

Драйгер төхөөрөмжийг орлого авч ИТХурлын балансад тусгасан байна. Сургалт сурталчилгааны зардалд Архигүй монгол хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүүхэд залуучуудад архиан согтуурахтай тэмцэх, тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн мэдлэг олгох сургалтыг иргэд болон төсвийн байгууллагын албан хаагчид, сургуулийн сурагчдын дунд зохион байгуулан бичиг хэргийн зардалд 250.0 мянган төгрөг, сум бүсийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тэмцээнд оролцох зардалд 274.7 мянган төгрөг, Хуулиа дээдлэе ААНэгж байгууллагуудын дунд зохион байгуулсан уралдаан тэмцээний зардалд 455.0 мянган төгрөг, шалгарсан байгууллага бүсийн тэмцээнд оролцох автомашины зардалд 192.5 мянган төгрөг, тэмцээнд амжилттай оролцсон иргэд байгууллагын урамшууллын зардалд 100.0 мянган төгрөг, тэмцээнд оролцох хүүхдүүдийн хувцасны зардалд 111.5 мянган төгрөгийг тус тус гаргасан байна. Анхан шатны баримтын бүрдэл сайн. Мөнгөн хөрөнгийн тайланг гүйлгээ гаргасан тухайн

сараар тайлагнаагүй жилийн эцсээр гаргасан байна. Шатахууны зардлыг ШТТөвөөс дараа тооцоогоор авч сарын эцэст тооцоо нийлэн төлбөрийг шилжүүлсэн байна.

Эмийн эргэлтийн сангийн талаар:

2013 оны эхний үлдэгдэл 21715.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 29003,4 мянган төгрөг, мөнгөн орлого 35629,3 мянган төгрөг, НДСангаас 53,5 мянган төгрөг, мөнгөн зарлага нь бараа материал авахад 24000,0 мянган төгрөг, ашиглалтын зардалд 956,1 мянган төгрөг, аймгийн ЭМГазрын даргын 2013.11.20-ны А/145 дугаар тушаалаар сэлбэг хэрэгсэлд 1355,2 мянган төгрөг, ажилчдад төлсөн урамшуулалд 1643,1 мянган төгрөг, програмын зардалд 440,0 мянган төгрөг зарцуулж цэвэр мөнгөн гүйлгээний дүн 7288,4 мянган төгрөг байна. Ашиглалтын зардлыг эмийн санчийн урамшуулалд 1217,8 мянган төгрөг, нягтлан бодогчийн урамшуулалд 365,3 мянган төгрөг, удирдлагын зөвлөлийн урамшуулалд 60,0 мянган төгрөг зарцуулсан байна. Ашиглалтын зардалд бичиг хэрэг 156,0 мянган төгрөг, томилолтын зардалд 192,0 мянган төгрөг, шатахууны зардалд 608,1 мянган төгрөг зарцуулсан байна.

Орлогын тайлангаар борлуулалтын орлого 35629,3 мянган төгрөг, ББӨ 23655,7 мянган төгрөг, ерөнхий удирдлагын зардалд 5321.6 мянган төгрөг зарцуулж 6742,0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Ерөнхий удирдлагын зардалд ажиллагсадад олгосон урамшуулал 1643,1 мянган төгрөг, ашиглалтын зардалд 956,1 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэлд 1355,2 мянган төгрөг, элэгдлийн зардалд 1277,3 мянган төгрөг байна. Тайлант оны эхэнд 2849,3 мянган төгрөгийн эмийн үлдэгдэлтэй байсан ба 24000,0 мянган төгрөгийн материал нэмэгдэж 23655,7 мянган төгрөгийн материал зарлага болгож 3186,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Эмийн тооллогыг сар бүрийн эцэст тооллогын комиссийн гишүүд тоолдог ба тооллогын дүнг авч нягтлан бодогч тооцоо бодсон байна. Эмийн орлогыг өдөр бүр харилцахад тушаадаг. Энэ нь кассын тайлангаар нотлогдож байна.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл тавилга хэрэгсэл 1542,4 мянган төгрөг, тоног төхөөрөмж 2170,2 мянган төгрөг, биет бус хөрөнгө 975,0 мянган төгрөг программ хангамж 440,0 мянган төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 5127,6 мянган төгрөгийн хөрөнгөтэй үүнээс хуримтлагдсан элэгдэл 2065,5 мянган төгрөг цэвэр үндсэн хөрөнгийн үлдэгдэл 3062,1 мянган төгрөг байна.

Тайлангийн авлагын эхний үлдэгдэл 74,3 мянган төгрөг байсан 53,5 мянган төгрөгийн авлага барагдаж жилийн эцсээр 27,6 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна. Тайлант онд өр төлбөр гаргаагүй байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах

- МУ-ын ЗГазрын 2012.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
- Сургуульд эко танхим байгуулахаар бэлнээр гарсан 1600,0 мянган төгрөгийн баримтын бүрдэл хангалтгүй дутуу байхад эко танхимыг 1000,0 мянган төгрөгөөр тохижуулахад захиалга өгсөн үлдэгдэл 600,0 мянган төгрөгөөр байгаль хамгаалагчийн эргүүл хийсэн шатахуун болон бусад зардалд зарцуулсан гэж тайлагнасан боловч баримтын бүрдэлгүйгээр гүйлгээ хийснийг төлүүлэх
- Бадын бөөрийн шагайн харвааны үеэр урлагийн тоглолтын хөлс 300.0 мянган төгрөг, сумын наадмын оройн хүндэтгэлийн хүлээн авалтанд урлагийн тоглолтын ажлын хөлс 500.0 мянган төгрөг нийт 800,0 мянган төгрөгийг олгохдоо ХХОАТатвар суутган шилжүүлээгүй тул төлүүлэхээр тус тус шийдвэрлэлээ.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.25